



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.09.06 № 05/7147.

танай 2019.08.22 ны № 01/2433. -т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ДЭД ДАРГА
Б.ЗАЯАБАЛ ТАНАА

Норцуй дарга
2019/9/6

Татварын ерөнхий газрын харьяа Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Юндэнгийн Лувсанцэрэн, Хэнтий аймгийн татварын хэлтсийн татварын орлогын тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Шагдарсүрэнгийн Оюунтөгс нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Харин Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтод "Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх" гэж заасан байхад нэр дэвшигч Ш.Оюунтөгс нь энэ шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахгүй байна.

Иймд тухайн албан тушаалд Төрийн албаны тухай хууль, тогтоомжид заасан шаардлагад нийцсэн этгээдийг нэр дэвшүүлэн томилохыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



X.ХАШБААТАР

Хашбаатар
2019.09.06